



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2019.04.12 № 10

Асуулга тавих тухай

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 2.1.3 дахь зүйлд аж үйлдвэрийг хөгжүүлэх I үе шат буюу 2016-2020 онд "Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх" гэж, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.50 дахь хэсэгт "Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ" гэж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан "Ноолуур" хөтөлбөрийн 2.1-д "Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх" гэж тус тус заасан.

Иймд Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.Ноолууран эдлэл болох эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар;


2.Түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, малчид, малчдын хоршоодод зориулсан түүхий эд бэлтгэлийг хэрхэн оновчтой зохион байгуулах, түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалахад малчид, үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;

3.Аж ахуйн нэгжид өнгөрсөн жил олгосон эргэлтйн хөрөнгийн зээл, түүний хэрэгжилт болон энэ жил үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

Хувийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ш.РАДНААСЭД

0000000043